



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.15 № 3/450
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Чингис хаан олон улсын нисэх буудал" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"Чингис хаан олон улсын нисэх буудал" ТӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"Чингис хаан олон улсын нисэх буудал" ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Чингис хаан олон улсын нисэх буудал" ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Чингис хаан олон улсын нисэх буудал” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б. М

Ц. АРАНЧИМЭГ

УХАА-122



ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

САГ-ын дарга,
Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг:

Аудитын менежер

Я.Самбууням

Утас: 261883

Цахим хаяг:

Аудитор: Б.Баярмаа

Утас: 260512

Цахим хаяг:

Бодит бүртгэл Аудит ХХК

Захирал Б.Бямбасүрэн

Утас: 88118264

Чанарын хяналтын менежер

Б.Бурмаа

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээ

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8.9.8 –д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны 9 дүгээр сарын 19-ны өдрийн А/93 тушаалаар батлагдсан журмын 2,7 дугаар заалтыг үндэслэн улсын төсвөөс санхүүждэг, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага ахуй нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/4/СТА-ТШЗСН/ аудит хийх ажлыг Бодит бүртгэл аудит ХХК санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Чингис Хаан олон улсын нисэх буудлын удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлангийн программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 20-ноос 2017 оны 3 дугаар сарын 10–ны хооронд хийхээр төлөвлөн Бодит бүртгэл аудит ХХК-ийн аудитор хэрэгжүүлэв.

Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2017 оны 2 дугаар сарын 20-нд цахимаар болон хэвлэсэн байдлаар Бодит бүртгэл аудит ХХК-нд ирүүлсэн байна.

Бодит бүртгэл аудит ХХК аудитыг 2017 оны 2 дугаар сарын 20-наас 2017 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, 2017 оны 3 дугаар сарын 15-нд Чингис Хаан олон улсын нисэх буудлын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Чингис Хаан олон улсын нисэх буудал нь Монгол улсын

- Улсын нисэхийн тухай
- Иргэний нисэхийн тухай
- Агаарын зайг нисэхэд ашиглах тухай
- Галт зэвсгийн тухай
- Гэрээт харуул, хамгаалалтын тухай
- Хилийн боомтын тухай
- Хөдөлмөрийн тухай
- Нягтлан бодох бүртгэлийн тухай
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль

зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Зорилго: Нисэх буудлын үйл ажиллагааг аюулгүй, шуурхай, соёлтой, үр ашигтай зохион байгуулж үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээг бүрдүүлсэн үндэсний шилдэг байгууллага болох.

Үйл ажиллагаа: Чингис Хаан олон улсын нисэх буудал нь Иргэний Нисэхийн Дүрэм-139, 140-ийн дагуу аэродром, аюулгүй байдлын үйлчилгээ явуулахаар гэрчилгээ авсан бөгөөд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Нисэхийн аюулгүй байдал, харуул хамгаалалт
- Аэродром ашиглалт
- Зорчигч үйлчилгээ
- Агаарын шуудангийн үйлчилгээ
- Авран туслах, гал унтраах
- Инженер техник

Чингис Хаан олон улсын нисэх буудлын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансны уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 8 горим, сорил 35-ыг гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна. Мөн нягтлан бодох бүртгэлийн бодлого нь санхүүгийн программ хангамжтай нийцсэн байна.

Чингис Хаан олон улсын нисэх буудлын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Чингис Хаан олон улсын нисэх буудлын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программ боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын түвшин:

Чингис Хаан олон улсын нисэх буудлын системийн хэмжээнд төлөвлөлтийн үе шатанд материаллаг төвшний хэмжээ буюу алдааг хүлээн зөвшөөрөх нийт

хэмжээг орлогын тайлангийн нийт орлогын хэмжээнд суурилан 2 хувиар буюу 182,1 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд, гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн баримжаанаас зөрүүтэй зүйл гараагүй болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Чингис Хаан олон улсын нисэх буудлын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн ажиллаж байна.

Төлөвлөгөөт орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Чингис Хаан олон улсын нисэх буудал нь 2016 оны батлагдсан төлөвлөгөөг сар, улирлын хуваарийн дагуу гүйцэтгэлийг хангах, зорилтот түвшингийн зардлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2016 онд үйл ажиллагааны орлогоор 23.103.7 сая төгрөг, үйл ажиллагааны бус орлогоор 2.250.3 сая төгрөг нийтдээ 25.354.1 сая төгрөг орлого олж, 20.401.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс үйл ажиллагааны урсгал зардалд 18,865.8 сая төгрөг батлагдсанаас 20.401.7 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсөв 1.535.9 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Чингис хаан олон улсын нисэх буудал нь шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулах тухай “Чингис хаан” ОУНБ-ын захирлын 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/30 дугаар тушаалаар шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээлэл, хугацаа, албан тушаалтны жагсаалтыг баталсан. Уг тушаалын дагуу холбогдох ажилтнууд мэдээллийг байршуулан ажиллаж байна.

1. Шилэн дансны төсөв гүйцэтгэлийн талаар: МУ-ыг ЗГ-ын 29 дүгээр тогтоолын хавсралт 6, хавсралт 9, хавсралт 17 дагуу мөн Санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг PDF файлаар

2. Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын талаар: МУ-ыг ЗГ-ын 29 дүгээр тогтоолын хавсралт 3, хавсралт 7, хавсралт 8, хавсралт 21, хавсралт 22 дагуу
3. Бусад мэдээллийн талаар: МУ-ыг ЗГ-ын 29 дүгээр тогтоолын хавсралт 8, хавсралт 10, мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг PDF файлаар, тухайн байгууллагад мөрдөгдөж буй үйлчилгээний хөлс түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг PDF файлаар тус тус байршуулсан байна.

Шилэн дансны цахим хуудсанд тавигдсан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 601 ширхэг гүйлгээгээр 24 тэрбум 674.8 сая төгрөгийн, зарлагын 190 ш гүйлгээгээр 17 тэрбум 193,2 сая төгрөгийн нийт 791 ажил гүйлгээ мөн хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтаар нийт 821.8 сая төгрөгийн ажил гүйлгээг ил тод, нээлттэй мэдээлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 38 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлбол: Тайлант онд дансны өр, авлага өсгөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, орлого, цалин, шатахуун, бараа материал, гадаад албан томилолтын зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 75 хувь, мөнгөн хөрөнгийн 75,2 хувь, нийт зардлын 80,5 хувь, нийт хөрөнгийн 76,9 хувийг тус тус эзэлж байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах зөрчил илэрсэн байна. Үүнд

1. Тайлант онд нийт 13 тэрбум 956.4 сая төгрөгийн авлагатай. Үүнээс: Дотоодын авиа компани – 12 тэрбум 276.3 сая төгрөг, Гадаадын авиа компани – 1 тэрбум 214.9 сая төгрөгийн авлага эзэлж байгаа нь нийт авлагын 96,7% юм. Дотоодын авиа компаниас авах авлагыг задалж үзүүлбэл: МИАТ ХК – 8 тэрбум 095.2 сая төгрөг буюу 66%, Аэромонголиа ХХК -1 тэрбум 257.9 сая төгрөг буюу 10%, Хүннү эйр ХХК – 2 тэрбум 921.8 сая төгрөг буюу 23,8%-ийг тус тус эзэлж байна. Тайлант онд нийт авлага 270.2 сая төгрөгөөр өссөн нь тус байгууллага 2016 оны 7-р сарын 01-нээс эхлэн агаарын замын төлбөрийг тооцоо үүсгэж чартерийн авлагаар бүртгэсэн боловч авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй нь голлон нөлөөлсөн байна.
2. Мөн тайлант онд нийт богино хугацаат өр төлбөр -11 тэрбум 930.3 сая төгрөг байна. Үүнээс: Иргэний нисэхийн ерөнхий газар – 11 тэрбум 283.0 сая төгрөг, бусад өглөг -416.0 сая төгрөг байна. Бусад өглөгийг задалбал: Хөрөнгийн барьцаа – 43.0 сая төгрөг бөгөөд энэ нь барьцааны хугацаа дуусахад байгууллагуудад өгөх өглөг, бусад өглөг нь 2017 оны 1 сард барагдсан тооцооны өглөгүүд байна. Үүнд: SITA – 44.8 сая төгрөг 2016 оны 4-р улирлын төлбөр, Дулааны 12 сарын төлбөр 41.4 сая төгрөг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2016 оны тооцоо 150.4 сая төгрөг, тэтгэмжинд 68.8 сая төгрөг, бараа материалын төлбөр 58.0 сая төгрөг гэх мэт төлбөрүүд эзэлж байна. Чингис хаан олон улсын нисэх буудал нь санхүүгийн тайлан тэнцлийг Иргэний нисэхийн ерөнхий газарт тушаадаг бөгөөд эдгээр тооцоонууд нь хоорондын тооцооноос үүссэн өглөгүүд байна. НӨАТ-ын тайлангаар 77.4 сая төгрөгийн үлдэгдэл дээр тооцоо нийлээгүй. Энэ нь Иргэний нисэхийн системээр 2628546 гэсэн регистрийн дугаараар нэг тайлагнадаг тул үлдэгдлийн баталгаа үйлдээгүй. 2017 оны 1-р улирлаас Чингис хаан ОУНБ нь санхүүгийн тайлан, татварын тайланг тусад нь тайлагнадаг болж, тусдаа кодтой болно. Энэ асуудал шийдвэрлэх шатандаа явж байна

Тайлант онд дансны өр, авлага өсгөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн : Зөвлөмж өгөх

3. Тайлант онд 207.0 сая төгрөгийн махны худалдан авалтанд тендерийг хувааж, нээлттэй тендер зарлаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5. Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно. гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн : Зөвлөмж өгөх

Материаллаг бус хэмжээний дараах зөрчил илэрсэн байна. Үүнд

4. Тооллогоор агуулахад мастик, өргөст тор зэрэг материал их хэмжээтэй байна 2016 онд 1 сард орж ирсэн 4255 кг буюу 17.1 сая төгрөг мастик нь чанарын шаардлага хангаагүй учраас гүйлгээнд оруулаагүй хадгалагдаж байна. Мөн 6.8 сая төгрөгийн өргөст торыг 3 жил дараалан гүйлгээнд оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн : Зөвлөмж өгөх

5. Бүтцийн өөрчлөлтөөр 2016 оны 05-р сарын 20-ны өдрийн Б/172 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн 5 ажилтанд тус бүр 36 сараар нийт 88.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь НББ-ийн тухай хуулийн 7.7-д заасан “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн : Албан шаардлага өгөх

6. Батлагдсан төсвийг дараах зардлуудаар хэтрүүлсэн. Үүнд

- Цалингийн зардал 146.3 сая төгрөг
- Гэрэл цахилгаан 90.1 сая төгрөг
- Тээвэр шатахууны зардал 6.2 сая төгрөг
- Усны зардал 15.9 сая төгрөг
- Сэлбэг, засварын зардал 87.4 сая төгрөг
- Бага үнэтэй түргэн элэгдэх 4.1 сая төгрөг
- Буцалтгүй тусламж 27.2 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн : Зөвлөмж өгөх

Материаллаг бүс залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 589.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба үүнээс 501.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 88.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд . “Бодит Бүртгэл Аудит” ХХК-ний хийсэн аудитаар 251.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн бөгөөд эдгээрийн зөвлөмжийн 80 хувийг хэрэгжүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Чингис Хаан олон улсын нисэх буудлын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, хавсралтууд 5 хуудсыг тус тус хавсаргав.



ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 4 зүйлс:

Асуудал 4	
Авлага,.....	1
Зардал	2
Мөнгөн хөрөнгө	3
Бараа материал	4

2017 оны 3 дугаар сар 10

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг : Чингис Хаан олон улсын нисэх буудлын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Чингис Хаан олон улсын нисэх буудлын удирдлага болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Авлага	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд дансны авлагыг 270.2 сая төгрөгөөр өсгөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийг мөрдөж, авлага барагдуулах, зохистой арга хэмжээ авч ажиллах.

Эрсдэлүүд

Авлага их хэмжээгээр найдваргүй болох, батлагдсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 4: Бараа материал	Тэргүүлэх ач холбогдол №4
---------------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт

Агуулахад мастик 17.1 сая төгрөг, өргөст тор 6.8 сая төгрөгийн чанарын шаардлага хангахгүй хөрөнгө гүйлгээнд оруулаагүй хадгалагдаж байна.

ҮАГ-ын зөвлөмж

Цаашид зөрчлийг дахин давтахгүй байх.

Эрсдэлүүд

Хөрөнгө эзгүйдэх, чанарын шаардлага хангахгүй үхмэл хөрөнгө бий болох, удирдлага буруу шийдвэр гаргах, үргүй зардал гаргах зэрэг эрсдэл бий болж байна.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Тэтгэмжийн зардал	Тэргүүлэх ач холбогдол №2
-------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Бүтцийн өөрчлөлтөөр 2016 оны 05-р сарын 20-ны өдрийн Б/172 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн 5 ажилтанд тус бүр 36 сараар нийт 88.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь байгууллагын дотоод журмыг үндэслэн нотлох баримтыг бүрдүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг дагаж, мөрдөж ажиллах.

Эрсдэлүүд

Батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулах, батлагдсан төсвөөс гадуур зардал гарах, зориулалт бусаар зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү зөрчлийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 3: Мөнгөн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №3
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллагын үнэлгээний хороо нь тайлант хугацаанд 207.0 сая төгрөгийн махны худалдан авалтанд тендерийг хувааж, нээлттэй тендер зарлаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах.

Эрсдэлүүд

Батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулах, батлагдсан төсвөөс гадуур зардал гарах, чанарын шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүн худалдан авах зэрэг эрсдэлүүд байна.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Анхан шатны баримтын хөтлөлт	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016 оны 11,12-р саруудын хөтлөгдвөл зохих хүнсний нэр төрлийн тайлан гаргаагүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй зэрэг зөрчил нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Эдгээр зөрчлүүд нь НББ-ийн тухай хуулийн 7.4-д “Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хууль, СТОУС-ыг мөрдөж цаашид зөрчлийг давтахгүй байх арга хэмжээг авч ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, орлого зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх, төсвийг зориулалт бусаар зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 3: Зардал	Тэргүүлэх ач холбогдол №2
--------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант оны 10,11,12-р сард жолооч нарын шатахууны тооцоог эд хариуцагч нярваар тооцоог бодуулсан, мөн механикч оношилгоо хийж авто машины сэлбэгийг өөрөө бэлтгэн нийлүүлж байгаа зэрэг зөрчил илэрлээ. Энэ нь байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг зөрчиж хяналтыг сулруулж, хөрөнгө эзгүйдэх эрсдэлийг бий болгож байна

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийг мөрдөж, цаашид зөрчлийг давтахгүй байх арга хэмжээг авч ажиллах

Эрсдэлүүд

Байгууллагын дотоод хяналт ажиллахгүй байх, батлагдсан төсвөөс гадуур зардал гаргах, зориулалт бусаар зарцуулах, холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

**ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН 2016 ОНЫ
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,734,112,673.09	17,359,408,044.07
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,859,593,881.17	2,478,207,330.67
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	18,999,210.00	1,984,950.00
31110	Төгрөг	18,999,210.00	1,984,950.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,840,594,671.17	2,476,222,380.67
3121	Төгрөг	1,511,214,378.97	2,450,249,288.45
31213	Арилжааны банк дахь харилцах	1,511,214,378.97	2,450,249,288.45
3122	Гадаад валют	329,380,292.20	25,973,092.22
31223	Арилжааны банк дахь харилцах	329,380,292.20	25,973,092.22
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
321	Үнэт цаас	-	-
33	АВЛАГА	13,686,229,461.35	13,956,355,180.08
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,997,083.54	13,271,053.43
33401	Дансны авлага /ТӨҮГ/	13,672,712,793.32	13,797,789,915.40
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		20,394,621.84
335	Бусад авлага	519,584.49	124,899,589.41
3351	Байгууллагаас авах авлага		124,630,104.93
3352	Хувь хүмүүсээс авах авлага	519,584.49	269,484.48
336	Зээлийн авлага	-	-
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	136,254,500.00	136,779,316.00
34600	Урьдчилж гарсан зардал	136,254,500.00	136,779,316.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,052,034,830.57	788,066,217.32
351	Түүхий эд материал	4,097,844.67	2,906,087.35
35130	Эм боох материал	4,097,844.67	2,906,087.35
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	4,667,702.30	1,640,290.71
354	Хангамжийн материал	1,034,307,344.94	777,972,339.26
35410	Бичиг хэргийн материал	101,836,623.18	62,165,175.07
35430	Сэлбэг хэрэгсэл	614,637,501.76	454,083,648.95
35440	Түлш, шатах тослох материал	449,600.00	663,466.67
35460	Хүнсний материал	72,175,832.93	68,855,225.54
35470	Бусад хангамжийн материал	245,207,787.07	192,204,823.03
35600	Мал амьтад	8,961,938.66	5,547,500.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	85,345,576.47	48,653,858,728.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	85,345,576.47	48,653,858,728.34
392	Биет хөрөнгө	-	48,482,378,091.68
39201	Барилга, байгууламж, орон сууц		21,297,424,364.56
39202	Хуримтлагдсан элэгдэл		(4,165,264,981.63)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		4,218,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(4,218,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		938,598,825.70
39206	Хуримтлагдсан элэгдэл		(617,434,571.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		1,623,898,752.66
39208	Хуримтлагдсан элэгдэл		(978,669,732.13)
39209	Зам, гүүрийн байгууламж		45,546,715,700.53
39210	Хуримтлагдсан элэгдэл		(19,152,699,569.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө		11,094,750,224.04
39215	Хуримтлагдсан элэгдэл		(7,104,940,921.58)
393	Биет бус хөрөнгө	85,345,576.47	171,480,636.66

39301	Програм хангамж	215,026,846.15	548,480,190.06
39302	Хуримтлагдсан элэгдэл	(129,681,269.68)	(376,999,553.40)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>16,819,458,249.56</u>	<u>66,013,266,772.41</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>11,006,102,098.22</u>	<u>11,930,311,462.90</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,006,102,098.22	11,930,311,462.90
411	Богино хугацаат үнэт цаас	-	-
4111	Төгрөг	-	-
4112	Гадаад валют	-	-
412	Богино хугацаат зээлийн өглөг	-	-
4121	Төгрөг	-	-
413	Өглөг	10,957,365,023.44	11,778,710,966.53
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	15,320,715.62	4,015,821.10
4136	Бусад өглөг	10,942,044,307.82	11,774,695,145.43
41361	Байгууллагад төлөх өглөг	10,484,784,363.15	11,283,075,857.18
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	532,000.00	
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	163,545,761.90	77,556,606.83
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	78,890,674.78	
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	214,291,507.99	414,062,681.42
414	Урьдчилж орсон орлого	48,737,074.78	151,600,496.37
41440	Бусад урьдчилж орсон орлого	48,737,074.78	151,600,496.37
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,813,356,151.34</u>	<u>54,082,955,309.51</u>
51	Засгийн газрын хувь оролцоо		
512	Хуримтлагдсан үр дүн	5,813,356,151.34	54,082,955,309.51
51210	Өмнөх үеийн үр дүн		48,573,500,666.92
51220	Тайлант үеийн үр дүн	5,813,356,151.34	5,509,454,642.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>16,819,458,249.56</u>	<u>66,013,266,772.41</u>

**ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН 2016 ОНЫ
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	22,989,153,829.15	25,354,108,408.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,989,153,829.15	25,354,108,408.35
120	Нийтлэг татварын бус орлого	22,989,153,829.15	25,354,108,408.35
120002	Хүүгийн орлого	25,037,924.34	59,243,718.92
120003	Торгуулийн орлого		113,400.00
120005	Түрээсийн орлого	1,165,536,334.60	1,192,771,203.38
120009	Бусад орлого	1,050,316,629.87	998,218,839.69
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	20,748,262,940.34	23,103,761,246.36
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	17,175,623,585.29	20,315,680,869.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,175,623,585.29	20,315,680,869.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,754,216,531.49	19,631,797,455.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,954,900,049.99	11,614,143,368.25
210101	Үндсэн цалин	5,240,579,279.69	5,696,158,888.45
210102	Нэмэгдэл	3,904,580,092.80	5,100,960,082.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	809,740,677.50	817,024,397.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,110,942,185.05	1,316,314,520.82
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,110,942,185.05	1,316,314,520.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	729,009,324.24	815,044,874.40
210301	Гэрэл, цахилгаан	474,691,394.59	513,823,809.38
210302	Түлш, халаалт	165,742,291.59	216,401,525.98
210303	Цэвэр, бохир ус	74,712,557.06	82,565,539.04
210304	Байрны түрээс	13,863,081.00	2,254,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,190,469,651.31	1,329,131,549.81
210401	Бичиг хэрэг	51,821,007.06	71,837,632.62
210402	Тээвэр, шатахуун	424,466,538.71	381,889,749.36
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210,044,038.71	230,616,368.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	486,984,330.64	612,126,338.23
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,153,736.19	32,661,460.61
2105	Нормативт зардал	326,345,243.74	225,259,305.78
210502	Хоол, хүнс	98,793,581.72	99,886,158.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	227,551,662.02	125,373,146.88
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	766,439,419.83	1,100,212,875.09
210601	Багаж, техник, хэрэгсэл	527,337,929.08	759,657,566.05
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,692,780.77	53,104,123.45
210604	Урсгал засвар	202,408,709.98	287,451,185.59
2107	Томилолт, зочны зардал	346,330.04	-
210701	Гадаад албан томилолт	346,330.04	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,672,514,772.19	3,215,374,847.07
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	44,782,159.88	38,344,000.00
210807	Газрын төлбөр	205,052,675.03	424,087,999.72
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	607,394.45	7,193,506.68
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	1,462,140,069.58	1,721,931,056.24
210813	Бусад зардал /ТӨҮГ/	959,932,473.25	1,023,818,284.43
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,249,555.10	16,316,113.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,249,555.10	16,316,113.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	421,407,053.80	683,883,414.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	421,407,053.80	683,883,414.61
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	137,777,079.56	293,280,427.25
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	283,629,974.24	390,602,987.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,813,530,243.86	5,038,427,538.74
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	14,147,989.76	557,068,698.67
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	14,147,989.76	557,068,698.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,251,873.95	86,041,594.82
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	15,251,873.95	86,041,594.82
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,103,884.19)	471,027,103.85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,812,426,359.67	5,509,454,642.59

**ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН 2016 ОНЫ
АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			8,564,844,630.76		8,564,844,630.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(8,564,844,630.76)		(8,564,844,630.76)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			5,812,426,359.67		5,812,426,359.67
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	5,812,426,359.67	-	5,812,426,359.67
D01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(5,812,426,359.67)		(5,812,426,359.67)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			48,573,500,666.92		48,573,500,666.92
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			5,509,454,642.59		5,509,454,642.59
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	54,082,955,309.51	-	54,082,955,309.51

**ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН 2016 ОНЫ
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	16,777,917,483.50	24,938,661,303.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,777,917,483.50	24,938,661,303.82
120	Нийтлэг татварын бус орлого	16,777,917,483.50	24,938,661,303.82
120009	Бусад орлого	1,010,859,116.18	3,047,946,603.34
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	15,767,058,367.32	21,890,714,700.48
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	15,845,858,428.37	24,213,079,585.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,845,858,428.37	24,213,079,585.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,845,858,428.37	24,213,079,585.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,811,332,573.10	11,978,747,241.02
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	9,811,332,573.10	11,978,747,241.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,420,833,030.00	2,969,403,445.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	2,420,833,030.00	2,969,403,445.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,224,878.32	315,970,945.38
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	250,224,878.32	315,970,945.38
2104	Хангамж, бараа материалын зардал	1,801,269,789.08	1,324,205,615.61
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	204,905,269.39	242,979,570.90
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	1,596,364,519.69	1,081,226,044.71
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,562,198,157.87	7,624,752,338.31
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,086,878,263.76	1,775,279,761.97
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	475,319,894.11	5,849,472,576.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	932,059,055.13	725,581,718.50
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	25,037,924.34	59,243,718.92
140007	Хүлээн авсан хүүний орлого	25,037,924.34	59,243,718.92
140008	Хүлээн авсан ногдол ашиг		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	100,910,118.80	166,212,987.92
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	100,910,118.80	166,212,987.92
2200	Дотоод эх үүсвэрээр	100,910,118.80	166,212,987.92
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	100,910,118.80	166,212,987.92
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(75,872,194.46)	(106,969,269.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	856,186,860.67	618,612,449.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,003,407,020.48	1,859,593,881.17
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,859,593,881.17	2,478,207,330.67